



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/181

Ховд

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад батлагдсан сум, багийн хөгжлийг дэмжих чадавжуулах хөтөлбөр арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- | | | |
|---------|--------------|--|
| Дарга: | Ш.Нохойжав | - Орон нутгийн өмчийн газрын дарга |
| Гишүүд: | Э.Цолмон | - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн |
| | Б.Дэлгэрмаа | - Хувийн хэвшлийн төлөөлөл |
| | Ж.Пүрэв-Очир | - Иргэний төлөөлөл |

Нарийн бичгийн дарга:

Ж.Батлхагва – Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Ж.Батлхагва /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД